



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2025 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

**Гүйцэтгэх захирлыг түр орлон
гүйцэтгэгч томилох тухай**

Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.9 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг, Авлигатай тэмцэх газрын 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 05/19106 тоот албан бичиг, “Эрчист монгол” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн 2025 оны 05 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгчээр Баасангийн Лхагва-Очирыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн түр томилсугай.

2. Компанийн Гүйцэтгэх захирлын нээлттэй сонгон шалгаруулалтыг 2026 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулж, үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо (Г.Туул)-д үүрэг болгосугай.

3. Гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгч Б.Лхагва-Очиртой Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ц.Түвшинзаяа)-д зөвшөөрсүгэй.

4. Гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгч Б.Лхагва-Очирын цалин урамшууллыг гэрээнд заасны дагуу тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Б.Анхбаяр)-т зөвшөөрсүгэй.

5. Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

6. Гүйцэтгэх захирлын ажлыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хүлээлцүүлж, үр дүнг танилцуулахыг Ажлын хэсэг (Л.Амгалан)-д үүрэг болгосугай.

7. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо (Г.Туул), цалин, урамшууллын хороо (Х.Ган-Очир) нарт тус тус даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ТҮВШИНЗАЯА



“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 47 дугаар тогтоолын хавсралт

Гүйцэтгэх захирлын ажил хүлээлцүүлэх
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ахлагч:	Л.Амгалан	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн
Гишүүд:	Д.Алтангэрэл	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн
	Ж.Галбадрах	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн
	Ж.Энхбаатар	ТОСК ТӨХХК-ийн Захиргаа удирдлагын газрын дарга
	О.Бат-Өлзий	ТОСК ТӨХХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Булганхишиг	ТОСК ТӨХХК-ийн Хүний нөөц, сургалт судалгаа хариуцсан мэргэжилтэн

___оОо___